

ЖАРГАЛАНТ СУМЫН ПРОГРЕСС СУРГУУЛЬД ХИЙСЭН ШАЛГАЛТЫН ТАНИЛЦУУЛГА

Нэг. Шалгалтын зорилго

Ховд аймгийн Засаг даргын баталсан 35/01/15 тоот удирдамжийн дагуу Жаргалант сумын Прогресс сургуулийн 2018, 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд төрийн өмч хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, хадгалалт, хамгаалалтын байдал, төсөв санхүү, нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийн хэрэгжилтэнд үнэлгээ дүгнэлт өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, эрсдэлээс урьдчилан сэргийлж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулан ажиллахад оршино.

Хоёр. Шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа

Санхүүгийн хяналт аудитын албанаас 2 хүний 2020 оны 10 дугаар сарын 22-ноос 11 дүгээр сарын 17-ны хооронд шалгалт хийлээ.

Гурав. Шалгалтанд хамрагдсан асуудал

Тус байгууллагын 2018, 2019 оны санхүүгийн үйл ажиллагааг анхан шатны болон нягтлан бодох бүртгэлд үндэслэн Монгол улсын санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн болон бусад хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар журмын хэрэгжилтийг нягтлан бодох бүртгэл, анхан шатны баримт материал, тайлан тэнцэлд тулгуурлан явуулав.

2017 оны санхүүгийн баримтанд Санхүүгийн хяналт аудитын албанаас шалгалтыг 2018 онд хийсэн тул энэ удаагийн шалгалтанд хамрагдаагүй болно.

Дөрөв. Шалгалтанд хамрагдсан объектын талаарх товч мэдээлэл

Жаргалант сумын Прогресс сургууль нь Эрүүл биетэй, эрдэм боловсролтой, идэвхи санаачилгатай, гэрэлт ирээдүйг цогцлоон бүтээх хүмүүнлэг иргэн төлөвшүүлэх эрхэм зорилго дэвшүүлэн дээрх зорилгын хүрээнд хүүхэд нэг бүрийн хөгжлийн төлөө үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллажээ. Боловсролын талаар төрөөс баримтлах бодлого, Засгийн газрын мөрийн хөтөлбөр, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан сургуулийн үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж ажиллаж байна.

Үйл ажиллагаандаа Боловсролын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, боловсролын үйлчилгээнд оролцогчидтой холбоотой хууль тогтоомж, тушаалыг мөрдлөгө болгон ажиллаж байна.

Багш ажилчдад эрх зүйн мэдлэг олгох, залуу багш нарын заах арга зүй, ур чадварыг нэмэгдүүлэх зорилготойгоор ур чадварын уралдааныг зохион байгуулж,

багш нар хууль, тогтоол, журам, албан даалгавартай танилцаад зогсохгүй харилцан заах арга зүйн туршлага судалсан ажлуудыг тогтмол зохион байгуулж байна.

Тус сургууль нь Монгол улсын Боловсролын тухай, Бага дунд боловсролын тухай, Төрийн албаны тухай, Төсвийн тухай, Хөдөлмөрийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Шилэн дансны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Монгол улсын бусад хууль эрх зүйн актуудыг удирдлага болгон ажил үйлчилгээний чанар, бүтээмжийг дээшлүүлэн улсын төсвийн санхүүжилтээр байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулж иржээ.

Тус Сургууль нь 2019 онд 76 орон тоотой ажиллахаас 76 орон тоотой, 52 багштай, 35 бүлэгтэй, дунджаар 1161 хүүхэдтэй ажиллахаас 1215 хүүхэдтэйгээр үйл ажиллагаагаа явуулж иржээ.

2018 онд тус сургуулийн нийт багш нарын 39%-ийг “Заах аргач”, 4%-ийг “Зөвлөх”, 41%-ийг “Тэргүүлэх”, 16%-ийг зэрэггүй, 2019 онд нийт багш нарын 42%-ийг “Заах аргач”, 2%-ийг “Зөвлөх”, 37%-ийг “Тэргүүлэх”, 19%-ийг зэрэггүй багш нар эзлэж байна.

Шалгагдах хугацааны Төрийн сангийн 100161715105, нэмэлт санхүүжилтийн 100161715405 тоот дансны хөрөнгийн эрх захирагчийн нэгдүгээр гарын үсгийг эрхлэгч О /2018 оны 11 сар хүртэл/, Э /2018 оны 11 сараас/ нар хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч Б /2019 оны 12 сар хүртэл/, С /2019.12 сараас/ нар зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулж, гүйцэтгэлд нь хяналт тавин ажиллаж ирсэн байна.

Тав. Төсвийн бүрдүүлэлт зарлага, санхүүжилтийн талаар

2018 онд тус Сургууль нь улсын төсвийн санхүүжилтээр 1058683.5 мянган төгрөг, үндсэн ажиллагааны орлогоос 85669.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 600.0 мянган төгрөг, нийт 1144952.5 мянган төгрөгөөр санхүүжихээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр улсын төсвөөс 1058683.5 мянган төгрөг, үндсэн ажиллагааны орлогоос 86269.1 мянган төгрөг, нийт 1144952.6 мянган төгрөгийг зарцуулж, 0.1 мянган төгрөгөөр батлагдсан төсвийг хэтрүүлжээ.

2018 онд нийт зардлын 61.1%-ийг цалин хөлсөнд, 7.6%-ийг НДШ-д, 17.4%-ийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд, 1.7%-ийг хангамж бараа материалын зардалд, 0.1%-ийг томилолтын зардалд, 3.5%-ийг бараа үйлчилгээний бусад зардалд, 8%-ийг тэтгэмж урамшуулалд, 0.6%-ийг бусад зардлуудад зарцуулжээ.

2019 онд тус Сургууль нь улсын төсвөөс-995542.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс-218128.1 мянган төгрөг, үндсэн ажиллагааны орлогоос-96219.0 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс-7413.0 мянган төгрөг, нийт 1317302.4 төгрөгөөр санхүүжихээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр улсын төсвөөс 995542.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 218128.1 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 104984.8 мянган төгрөг, өмнөх оны үлдэгдлээс 8478.4 мянган төгрөг, нийт 1327133.6 мянган төгрөгийг зарцуулж, 9831.2 мянган төгрөгөөр батлагдсан төсвийг хэтрүүлжээ.

2019 онд нийт зардлын 65.7%-ийг цалин хөлсөнд, 8.2%-ийг НДШ-д, 16.3%-ийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд, 0.3%-ийг хангамж бараа материалын зардалд, 4.9%-ийг бараа үйлчилгээний бусад зардалд, 4.3%-ийг тэтгэмж урамшуулалд, 0.1%-ийг урсгал засварын зардалд, 0.1%-ийг томилолтын зардалд, 0.1%-ийг нормативт зардалд тус тус зарцуулжээ. Дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгтээр харуулбал:

ДД	Зардлын төрөл	2018 он /мянган төгрөгөөр/			2019 он /мянган төгрөгөөр/		
		Төл-гөө	Гүйцэтгэл	-Хэтрэлт, хэмнэлт	Төл-гөө	Гүйцэтгэл	-Хэтрэлт, хэмнэлт
1	Цалин хөлс	703060.6	699860.6	3200.0	871880.4	871880.4	0
2	НДШ	84367.2	87567.2	-3200.0	108985.1	108985.1	0
3	Гэрэл цахилгаан	5029.1	5029.1	0	4913.8	4913.8	0
4	Түлш халаалт	175341.2	172141.2	3200.0	189448.8	189448.8	0
5	Ус	22048.3	22048.3	0	22180.3	22180.3	0
6	Хоол			0			
7	Эм	361.7	551.7	-190.0	356.2	356.2	0
8	Бичиг хэрэг	786.6	9117.2	-8330.6	809.5	706.0	103.5
9	Тээвэр шатахуун	150.0	150.0	0	100.0	100.0	0
10	Шуудан холбоо	1278.4	1548.4	-270.0	1222.8	1222.8	0
11	Ном хэвлэл	2138.5	2409.3	-270.8	744.7	661.0	83.7
12	БҮТЭЗ	1100.9	6251.5	-5150.6	1262.8	1262.8	0
13	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	718.0	898.0	-180.0			
14	Томилолт				566.6	128.0	438.6
15	Зөөлөн эдлэл нормын хувцас	1588.4	1797.7	-209.3	1570.4	1678.1	-107.7
16	Хог хаягдал	393.2	367.2	26.0	404.7	404.7	0
17	Урсгал засвар	2552.4	2997.9	-445.5	1585.2	1585.2	0
18	Бусад зардал	1572.7	1483.2	89.5	8951.0	7609.3	1341.6
19	Аудитын хөлс	382.0	382.0	0	485.7	1008.0	-522.3
20	Хичээл үйлдвэрлэлийн дадлага	50310.9	38579.5	11731.4	45361.4	56754.8	-11393.4
21	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж	4848.3	4848.3	0			

22	Хөдөө ОН-т ажилласны тэтгэмж	32525.6	32525.7	-0.1			
23	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	54398.4	54398.4		56473.0	56248.2	224.8
	Дүн	1144952.4	1144952.2	0	1317302.4	1327133.6	9831.2

2018 онд НДШ-ийн зардлыг 3200.0 мянган төгрөгөөр, эм 190.0 мянган төгрөгөөр, бичиг хэргийн зардлыг 8330.6 мянган төгрөгөөр, шуудан холбооны зардлыг 270.0 мянган төгрөгөөр, ном, хэвлэлийн зардлыг 270.8 мянган төгрөгөөр, БҮТЭЗ-ийн зардлыг 5150.6 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийг 180.0 мянган төгрөгөөр, зөөлөн эдлэл, нормын хувцасны зардлыг 209.3 мянган төгрөгөөр, урсгал засварын зардлыг 445.5 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлж, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх, бараа үйлчилгээний бусад зардал, хог хаягдал зайлуулах, цалин хөлс, түлш халаалтын зардлыг тус тус хэмнэн зарцуулж ажилласан байна.

2019 онд нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлыг 107.7 мянган төгрөгөөр, аудит баталгаажуулалтын зардлыг 522.3 мянган төгрөгөөр, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 11393.4 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлж, хангамж бараа материалын зардал, томилот, зочны зардал, тэтгэмж урамшууллын зардлыг тус тус хэмнэн ажиллажээ.

Тус байгууллага нь 2018 оны эхэнд 4953.8 мянган төгрөгийн авлагатай байсан бол оны эцэст 1702.0 мянган төгрөгийн авлагатай болж авлага 3251.8 мянган төгрөгөөр буурсан, оны эхэнд өглөггүй байсан бол оны эцэст 305.6 мянган төгрөгийн өглөгтэй болжээ.

Үндсэн хөрөнгө 2018 онд 3781054.3 мянган төгрөг байснаа 2099706.9 мянган төгрөг болж, 1681347.4 мянган төгрөгөөр буурсан, бараа материал 76594.5 мянган төгрөг байснаа 86133.9 мянган төгрөг болж, 9539.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн хөдөлгөөний талаар:

2018 онд барилга 19173.3 мянган төгрөгөөр, тоног төхөөрөмж 4240.9 мянган төгрөгөөр, тавилга эд хогшил 17222.5 мянган төгрөгөөр, ном 5367.1 мянган төгрөгөөр, програм хангамж 350.0 мянган төгрөгөөр, газар 123300.0 мянган төгрөгөөр /Жаргалант сумын Иргэдийн Төлөөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 10, 209, 234 дүгээр тогтоолуудаар тус тус орлогод авсан/ дахин үнэлгээгээр барилга 11207.0 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

Тайлант онд дахин үнэлгээгээр барилга 1388344.0 мянган төгрөгөөр, тоног төхөөрөмж 6077.9 мянган төгрөгөөр, тавилга эд хогшил 15057.2 мянган төгрөгөөр тус тус хорогджээ.

Тайлант онд 21769.7 мянган төгрөгийн хөрөнгө акталж, 419752.2 мянган төгрөгийн хөрөнгийг Жаргалант сумын 14 дүгээр цэцэрлэгт шилжүүлж, /Жаргалант сумын Иргэдийн Төлөөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 288 дугаар тогтоолоор акталсан, Жаргалант сумын Иргэдийн Төлөөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 99 дүгээр тогтоолоор шилжүүлсэн/ данс бүртгэлээс хассан байна.

2018 онд 99132.1 мянган төгрөгийн элэгдэл байгуулж, 635536.2 мянган төгрөгийн акталсан, дахин үнэлгээгээр хасагдсан хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл хасч, хуримтлагдсан элэгдэл 297869.7 мянган төгрөг болсон байна.

Тус байгууллага нь 2019 оны эхэнд 1702.0 мянган төгрөгийн авлагатай байсан бол 35.0 мянган төгрөгөөр буурсан, 305.6 мянган төгрөгийн өглөгтэй байсан бол оны эцэст 366.3 мянган төгрөгийн өглөгтэй болж, 60.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө 2019 онд 2099706.9 мянган төгрөг байснаа 2100974.7 мянган төгрөг болж 1267.8 мянган төгрөгөөр өссөн, бараа материал 86133.9 мянган төгрөг байснаа 127723.8 мянган төгрөг болж 41589.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн хөдөлгөөний талаар:

2019 онд тоног төхөөрөмж 5461.0 мянган төгрөгөөр, тавилга, эд хогшил 9010.0 мянган төгрөгөөр, ном 5702.5 мянган төгрөгөөр /Жаргалант сумын Иргэдийн Төлөөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 289 дүгээр тогтоолуудаар орлогод авсан/ тус тус өссөн байна.

Тайлант онд 18905.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг Жаргалант сумын Иргэдийн Төлөөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 297 дугаар тогтоолоор акталж, данснаас хасжээ.

2019 онд 69293.6 мянган төгрөгийн элэгдэл байгуулж, 16249.1 мянган төгрөгийн акталсан хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл хасч, хуримтлагдсан элэгдэл 350914.2 мянган төгрөг болсон байна.

2018 оны нэмэлт санхүүжилтийн дансаар:

Тус сургуулийн нэмэлт санхүүжилтийн 100161715405 тоот дансаар 2018 онд дараах төрлийн гүйлгээнүүд хийгджээ. Үүнд:

- Цайны газрын түрээсийн орлого 1535000 төгрөг
- Спорт заалны түрээсийн орлого 1318000 төгрөг
- Сургалтын төлбөрийн орлого 91749500 төгрөг
- Боловсрол соёл урлагийн газраас дэмжлэг 7793390 төгрөг
- ХОИС-аас дадлагын хөлсөнд 280000 төгрөг

- Нийгмийн даатгалын сангаас жирэмсэн, амаржсаны тэтгэмжинд 34475833 төгрөг, нийт 137151723 төгрөгийн орлого орсныг дараах байдлаар зарцуулжээ. Зарцуулалтыг задалбал:

- Үндсэн үйл ажиллагаанд буюу цалин хөлс, хичээлийн хэрэглэгдэхүүнд 85804100 төгрөг
- Дадлага удирдсан багш нарын урамшуулалд 280000 төгрөг
- Жирэмсэн, амаржсаны тэтгэмжинд 34475833 төгрөг
- Хүн амын орлогын албан татварт 5793390 төгрөг
- Түрээсийн орлогын 20 хувийг өмчийн санд 320000 төгрөг
- Материалын зардалд 513000 төгрөг
- Хичээлийн хэрэглэгдэхүүн, кабинетийн тохижилтонд 1487000 төгрөг
- Үлдэгдлийг татан төвлөрүүлэлт 8478400 төгрөг, нийт 137151723 төгрөгийг зарцуулжээ.

2019 оны нэмэлт санхүүжилтийн дансаар:

Тус сургуулийн нэмэлт санхүүжилтийн 100161715405 тоот дансаар 2019 онд дараах төрлийн гүйлгээнүүд хийгджээ. Үүнд:

- Цайны газрын түрээсийн орлого 2104400 төгрөг
- Спорт заалны түрээсийн орлого 350000 төгрөг
- Сургалтын төлбөрийн орлого 107978933 төгрөг
- Урьд оны үлдэгдэл 8478400 төгрөг
- Боловсрол соёл урлагийн газраас дэмжлэг 2000000 төгрөг
- Зорилтот бүлгийн хүүхдүүдийн суралцах орчинг нэмэгдүүлэх чиглэлээр “Бэрхшээлийг боломж болгоё” төсөлд 15804000 төгрөг Олон улсын байгууллагаас
- ХОИС-аас дадлагын хөлсөнд 396000 төгрөг
- Номны үнэ 4434600 төгрөг
- Боловсрол соёл, урлагийн газраас санхүүгийн дэмжлэг 30200000
- Нийгмийн даатгалын сангаас жирэмсэн, амаржсаны тэтгэмжинд 11668016 төгрөг, нийт 183414349 төгрөгийн орлого орсныг дараах байдлаар зарцуулжээ. Зарцуулалтыг задалбал:

- Үндсэн үйл ажиллагаанд буюу цалин хөлс, хичээлийн хэрэглэгдэхүүнд 116433300 төгрөг
- Дадлага удирдсан багш нарын урамшуулалд 396000 төгрөг
- Жирэмсэн, амаржсаны тэтгэмжинд 11668016 төгрөг
- Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжинд 93433 төгрөг
- Ашгийн татварт 424000 төгрөг

- Түрээсийн орлогын 20 хувийг өмчийн санд 420880 төгрөг
- Боловсрол соёл урлагийн газрын номны үнэ 4434600 төгрөг
- Зорилтот бүлгийн хүүхдүүдийн суралцах орчинг нэмэгдүүлэх чиглэлээр “Бэрхшээлийг боломж болгоё” төслийн хүрээнд 14755000 төгрөг
- Гүйлгээ залруулахад 705000 төгрөг
- Багшийн мэргэжил дээшлүүлэх захиалгат сургалтанд 2542500 төгрөг
- Цалин хөлсөнд 30200000 төгрөг
- Үлдэгдлийг татан төвлөрүүлэлт 1341620 төгрөг, нийт 183414349 төгрөгийг зарцуулжээ.

Зургаа. Шалгуулагчийн ололттой талууд

Тус сургууль байгуулагдсан цагаасаа хойш удирдлагын зөв менежмент, алсыг харсан бодлогын үр дүнд шинэхэн байгуулагдсан тус сургууль богино хугацаанд аймгийн шилдэг үнэлгээтэй сургуулиар 7 удаа, аймгийн аварга сургуулиар 9 удаа, дэд аварга сургуулиар 4 удаа шалгарч, ЭЕШ болон сургалтын чанар, үр дүнгээрээ 2007 онд шилдэг үнэлгээтэй сургууль, 2008 онд хошой шилдэг үнэлгээтэй сургууль, 2013 онд улсын “ТОП” үнэлгээтэй сургуулиар шалгарч байжээ.

Мэргэжлийн хичээлийн олимпиадад сургууль байгуулагдсан цагаасаа эхлэн 12 –удаа аварга, 4 –удаа дэд байрт шалгарч байжээ.

Багш, сурагчид улсын олимпиадад амжилттай оролцож Химийн багш Ч.Энхжаргал хошой аварга, мөнгө, хүрэл медаль, дизайн технологийн багш А.Баасанхүү, Д.Оюунсүрэн нар хошой аварга, математик-мэдээлэл зүйн багш Э.Цэгмэд мэдээлэл зүйн олимпиадад хүрэл медаль, Бага ангийн багш П.Бямбацэрэн сэтгэх чадварын бүтээлч багш улсын уралдаанд хошой мөнгө, Газарзүйн багш Д.Дэлгэржаргал улсын ур чадварын уралдаанаас мөнгө, БАЗАН-ын баг “цахим хэрэглэгдэхүүн” улсын уралдааны тэргүүн байр тус тус хүртсэн байна.

Мэргэжлийн хичээлийн улсын олимпиадад Монгол бичгийн хичээлээр сурагч Ж.Ганцоож мөнгө, Орос хэлний хичээлээр сурагч Б.Ганцэцэг мөнгө, Мэдээлэл зүйн хичээлээр сурагч П.Дэлгэрмөрөн хүрэл, Газарзүйн хичээлээр сурагч Т.Батбуян хүрэл медаль хүртэж, 2019 онд 2008, 2009 онд УАШ-х жүдо бөхийн тэмцээнд сурагч А.Бодьгэрэл улсын аварга, 2008 онд Сурлага номинацид Л.Гэрэлмаа, 2010 онд “Байгаль хамгаалагч” номинацид Г.Есүхэй, 2018 онд Спортлог сурагч номинацад Т.Буяннэмэх нар Монгол улсын ШИЛДЭГ СУРАГЧ-аар тус тус шалгарсан байна.

2019 оны чанарын үнэлгээний судалгаагаар Математик, Монгол хэл, Англи хэл, Физикийн хичээлийн дундаж оноогоороо улсын дунджаас хол давсан амжилтыг үзүүлж аймагтаа тэргүүлсэн байна.

Тус сургууль байгуулагдсанаас хойш Монгол улсын Гавъяат багш -1, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон-1, Алтан гадас одон-3, Хөдөлмөрийн хүндэт медаль-2, Ардын боловсролын тэргүүний ажилтан - 14, Соёлын тэргүүний ажилтан -1, доктор-2, магистр-9, зөвлөх багш-5, тэргүүлэх зэрэгтэй багш-34, заах аргач багш -28 төрөн гарсан байна.

Улсын чанартай олимпиадад 408 хүүхэд оролцуулж, нийт 30 /Алт-10, мөнгө-19, хүрэл-11/ медаль хүртсэн, олон улсын эссэ бичлэгийн уралдаанд нэгдүгээр байр-4, хоёрдугаар байр-6, гуравдугаар байр-4, нийт 14 сурагч эхний байруудыг эзэлсэн, Ховд аймгийн 2019 оны Улсын Мэргэжлийн хичээлийн олимпиадын II даваанд 18 төрлөөр 60 гаруй багш, сурагчид оролцож гүйцэтгэлийн дундаж нь 3.84% хүрч аймагт тэргүүн байр, Ховд аймгийн 24 сургуулийн дунд зохион байгуулагддаг УИХ-ийн гишүүн С. Бямбацогтын нэрэмжит “Оюуны Их сорилго” олон төрөлт багийн олимпиадад 3 дахь жилдээ амжилттай оролцож дэд байр, Сэтгэх чадварын хичээлээр Н.Пүрэвсүрэн, Нийгэм судлал хичээлээр Г.Баяртунгалаг багш нарын бэлтгэсэн сурагчид хамгийн өндөр оноо авч багш нар нь Шилдэг багшаар шалгарсан зэрэг амжилтуудыг үзүүлжээ.

Долоо. Өмнөх шалгалтаар илэрсэн зөрчил, түүнийг арилгасан талаар

2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” санал дүгнэлт өгчээ.

2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар тайлант онд 305.6 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн зөрчилд өглөг, авлага үүсгэхгүй ажиллах зөвлөмж өгчээ.

2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” санал дүгнэлт өгчээ.

2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийг 9831.3 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан зөрчилд зөвлөмж өгсөн байна.

2018 онд 2016, 2017 оны санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт аудитын албанаас хяналт шалгалт хийж, Захиралд мэргэжлийн зэргийн нэмэгдэл олгосон, Сахилгын шийтгэлтэй ажилтанд нэг удаагийн урамшуулал олгосон, давсан орлогыг шууд зарцуулсан, сургуулийн эмчийн оронд мэргэжлийн бус хүнийг түр томилсон, үр дүнгийн урамшууллыг ажлыг бодитой дүгнэлгүйгээр хавтгайруулан олгосон, сургалтын менежерт илүү цагийн хөлс олгосон зэрэг зөрчлүүд илрүүлж, 710.4 мянган төгрөгийн акт, зөрчил арилгуулах тухай албан шаардлагуудыг тус тус өгч байжээ.

2018 онд дээрх акт, албан шаардлага бүрэн барагдуулж ажилласан байна.

2018 онд Ховд аймгийн Нийгмийн даатгалын хэлтсээс Прогресс сургуулийн 2016, 2017 онуудын санхүүгийн баримтанд Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж, гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилт, даатгалын хамрагдалт, даатгуулагчдад олгосон хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалт, төлөлтийн тайланд хяналт шалгалт хийжээ.

Шалгалтаар зөрчил дутагдал илрээгүй бөгөөд нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг зөв тодорхойлж, ажиллагсдыг нийгмийн даатгалд бүрэн хамруулж байх, нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр төлж, өр авлага үүсгэхгүй байх, нийгмийн даатгалын дэвтрийн бичилт, баталгаажуулалтанд хяналт тавьж, даатгуулагчдын нийгмийн баталгааг хангах зэрэг зөвлөмжүүдийг өгсөн байна.

Найм. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын талаар

Шалгалтаар санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил дутагдлаас гадна дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. 2019 онд 600000 төгрөгийн цалингийн урьдчилгаа олгоод төсвийн жилд суутган аваагүй авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтыг

2. Нийгмийн ажилтанд орон нутагт ажилласны нэмэгдэлд 151410 төгрөг дутуу олгосон нь Засгийн газрын /2018 онд/ 2001 оны 90 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 1 дэх заалт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтын 3 дахь заалтуудыг

3. 2018 оны 01 дүгээр сард Багш М-д тушаал, шийдвэргүйгээр ур чадварын нэмэгдэлд 53529 төгрөг, 2018 оны 02 дугаар сард Багш Д-д тушаал, шийдвэргүйгээр ур чадварын нэмэгдэлд 55037 төгрөг, нийт 108566 төгрөг олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7 дахь заалтуудыг, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 2 дахь заалт, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2010 оны 362/112/183 дугаар тушаалын 9 дүгээр заалтуудыг

4. Захирлын 2018 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн А/28 дугаар тушаалаар багш Ч-д сахилгын шийтгэл ногдуулсан байхад 2018 оны 12 дугаар сард ур чадварын нэмэгдэлд 93608 төгрөг олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.4 дахь заалт, Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 5 дахь заалтыг

5. Сургуулийн Нийгмийн ажилтан Э-г 2019 оны 02 дугаар сард ТҮБД-3-1 дүгээр шатлалаар цалинжуулахаар Захирлын Б/08 тоот тушаал гарсан байхад ТҮБД-4-2 дугаар шатлалаар цалинжуулж, 174806 төгрөг илүү тооцон олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7 дахь заалтууд, Засгийн газрын 2019 оны 25 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг, Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтыг, Захирлын 2019 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн Б/08 тоот тушаалыг

6. “Бэрхшээлийг боломж болгоё” төслийн хүрээнд Азийн хөгжлийн банкнаас ирсэн санхүүжилтийн үлдэгдэл 164000 төгрөгийг төслийн хаалтанд зарцуулахаар төлөвлөсөн боловч данс бүртгэлд тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дүгээр зүйл, Засгийн газрын 2012 оны 276 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 7.2, 7.4 дахь заалтыг

7. 2019 оны санхүүгийн тайланд ХС ХХК-иас 1083200 төгрөгийн Х ХХК-иас 940800 төгрөгийн авлагатай, БО ХХК-д 2081600 төгрөгийн өртэй байхад Х ХХК-иас 2000000 төгрөгийн авлагатай, БО ХХК-иас 2110600 төгрөгийн авлагатай, ХС ХХК-д 4192200 төгрөгийн өртэй гэж тайлагнасан, тайлант жилд өглөг авлага үүсгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.4.2, 14.4.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтыг

8. Тус сургууль нь 2018 оны урлагийн үзлэгт эхний байруудад шалгарсан сурагчдад 264000 төгрөгийн мөнгөн шагнал олгосон нь Хамтын гэрээний 8.10 дахь заалтыг

9. Худалдан авах ажиллагаа зохион байгуулахдаа төрийн худалдан авах ажиллагааны журам, тендерийн жишиг баримт бичигт заасан зарим маягтуудыг ашиглаагүй нь Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийг, Сангийн сайдын 2013 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 125 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтыг

10. Сургуулийн Захирлын зарим тушаалууд дугааргүй, он сар өдөр бичээгүй зэрэг зөрчлүүд илэрч байгаа нь Архивын ерөнхий газрын даргын 2009 оны 68 дугаар тушаалаар баталсан Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, Архивын ерөнхий газрын даргын 2007 оны 59 дүгээр тушаалаар баталсан “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

Өргөдлийн талаар:

Энэ удаагийн шалгалтаар Багш ажилчдаас ирүүлсэн өргөдлийн дагуу Багш Н-д ажилласан хугацааны ээлжийн амралтын олговорт 597491 төгрөг олгоогүй нь

Хөдөлмөрийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1, 79 дүгээр зүйлийн 79.1 дахь заалт, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалын 1 дүгээр хавсралтын 12, 14 дахь заалтуудыг зөрчсөн тул нөхөн олгуулахаар шийдвэрлэв.

Цагаар ажиллаж байгаа багш нарын хувьд Хөдөлмөрийн тухай хуулийн 23³.2, 23³.3 дахь заалтад заасны дагуу хөдөлмөрийн гэрээ, дотоод журам, хамтын гэрээнд ээлжийн амралт олгох талаар тусгагдаагүй байна.

Энэ удаагийн шалгалтаар 4211481 төгрөгийн зөрчил илэрснээс 1289881 төгрөгийн зөрчилд акт тогтоов. Үүнээс 540980 төгрөгийг орон нутгийн төсөвт оруулахаар, 748901 төгрөгийг ажилтанд нөхөн олгуулахаар Улсын ахлах байцаагчийн акт тогтоож, 2921600 төгрөгийн зөрчлийг дахин гаргахгүй байх, зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага бичлээ.

Ес. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар

Шилэн дансны нэгдсэн системд 2018, 2019 оны байдлаар мэдээг бүрэн байршуулсан байна.

2020 оны 12 дугаар сарын байдлаар мэдээллийг бүрэн, хугацаанд нь байршуулсан байна.

2018, 2019 оны 1, 2, 3, 4 дүгээр улиралд Шилэн дансны нэгдсэн системээр шилэн дансны тайлангаа илгээсэн байна.

Арав. Дүгнэлт

Тус байгууллага нь санхүүгийн тайлангаа хуулийн хугацаанд гаргаж, зохих байгууллагаар баталгаажуулан, тушааж хэвшсэн байна.

Анхан шатны баримтын бүрдэл, нягтлан бодох бүртгэл хэвийн хэмжээнд явагдаж байгаа боловч санхүүгийн тайлангийн жилд өглөг, авлага үүсгэж Төсвийн тухай хуульд заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Арван нэг. Цаашид авах арга хэмжээний санал

Жаргалант сумын Прогресс сургуульд:

1. Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах.
2. Худалдан авах ажиллагааг хууль, худалдан авах ажиллагааны журамд нийцүүлэн бэлтгэх, зохион байгуулах.
3. Цалин хөлсийг хууль эрх зүйн хүрээнд тооцооллын алдаагүй тооцож, олгох. Нягтлан бодогч цалин хөлсийг тооцоолохдоо хянаж олгох
4. Байгууллагын хөдөлмөрийн хамтын гэрээ, дотоод журмыг хууль, эрхзүйн баримт бичигт нийцүүлэн шинэчилж мөрдөх.

5. Бэлэн мөнгөний үлдэгдлийг данс бүртгэлд тусгаж байх, мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөж ажиллах.

6. Хамтын гэрээ, дотоод журмыг мөрдөж ажиллах.

7. Төсвийн жилд өр, авлага үүсгэхгүй, санхүүгийн хариуцлагатай ажиллах.

8. Тушаал шийдвэрийг зөв төлөвлөж үндэслэлтэй гаргаж байх, байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт, дүрэм журмуудыг мөрдөж ажиллах.

Шалгалтаар илэрсэн төлбөр зөрчлийг дахин давтан гаргахгүй ажиллаж, зөрчлийг арилгах талаар тодорхой ажил зохион байгуулж, хийсэн ажлын тайлан, биелэлтийг албан бичгээр 2020 оны 12 дугаар сарын 25-ны дотор багтаан ирүүлэх.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ АУДИТЫН АЛБА